


ХИМИЙН ХОРДЛОГЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН 7 ХОНОГИЙН МЭДЭЭ


НЭГ. Угаарын хийн цочмог хордлогын мэдээ

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хор судлал, шуурхай удирдлагын албанд 2024 оны 12 дугаар сарын 29-ний өдрөөс 2025 оны өдрөөс 12 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар буюу **эпидемиологийн 1-50 дугаар долоо хоногт** нийт Нийслэлийн 7 дүүрэг, 12 аймагт **2192** хүн угаарын хийн хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан.



Угаарын хийн хордлогод өртсөн иргэдийг байршлаар авч үзвэл:

Угаарын хийн хордлогод өртсөн 2192 тохиолдлын 96% /2092/ нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн бол, 4% /100/ нь орон нутагт (Баян-Өлгий /40/, Дорнод /4/, Орхон /11/, Өмнөговь /9/, Сэлэнгэ /6/, Төв/16/, Дорноговь /4/, Дархан /4/, Говь-Алтай /3/, Баянхонгор /1/, Дундговь /1/, Хэнтий /1/) бүртгэгдсэн байна.




Нийслэлд угаарын хийн хордлогод өртсөн тохиолдлыг дүүрэг тус бүрээр авч үзвэл хамгийн өндөр буюу **664** тохиолдол Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн байна.

ЭПИДЕМИОЛОГИЙН 50 ДУГААР ДОЛОО ХОНОГТ

(2025.12.7 – 12.13)

2025 оны эпидемиологийн 50 дугаар долоо хоногт 60 угаарын хийн хордлого бүртгэгдсэн байна. Өмнөх оны мөн үеэс 38.8 хувиар өссөн бол 5 жилийн дунджаас 11.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна.




ХОЁР. Бусад химийн бодисын цочмог хордлогын мэдээ

Цэргийн төв эмнэлгийн харьяа Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд **эпидемиологийн 1-50 дугаар долоо хоногт** нийт **1354** иргэн химийн цочмог хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна.


768Эмнэлгийн
тусламж авч буцсан**586**Хэвтэн эмчлүүлж
эдгэрч гарсан**0**

Нас барсан

Эрэгтэй
47%Эмэгтэй
53%

Химийн хордлогыг насны бүлгээр авч үзвэл 0-9 буюу бага насны хүүхдүүд хамгийн их хордлогод өртөж байна.

2025 оны **эпидемиологийн 50 дугаар долоо хоногт** химийн цочмог хордлогод өртсөн **24** хүн хандаж эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна. Энэ үзүүлэлт нь өмнөх оны мөн үеээс 50 хувиар, сүүлийн 5 жилийн дунджаас 122 хувиар тус, тус өссөн үзүүлэлттэй байна.



Хүснэгт 1. Химийн цочмог хордлого, шалтгаанаар (Эпи – 50 долоо хоногт)

№	Шалтгаан (Сэдэл)	Санаатай	Санамсаргүй	Нийт
1	Химийн бодисын хордлого	1	8	9
2	Эмийн хордлого	9	6	15
Нийт		10	14	24

Нийт 24 хордлогын тохиолдол бүртгэгдсэнээс 15 (62.5%) нь эмийн хордлого, 9 (37.5%) нь химийн бодисын хордлого байна. Санамсаргүй хордлого 14 (58.3%) тохиолдол, санаатай хордлого 10 (31.7%) тохиолдол тус, тус бүртгэгдсэн байна. Энэ нь эм болон химийн бодисыг буруу хэрэглэх, хадгалах дадал сул байгааг илтгэн, урьдчилан сэргийлэх сургалт, мэдээллийг нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна.

-o0o-